



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН 2016 ОНЫ НЭГДСЭН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ



АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

*ОРОН НУТГИЙН ТӨСВИЙГ ҮР АШИГТАЙ, АРВИЛАН ХЭМНЭЛТТЭЙ
ТӨЛӨВЛӨЖ, ЗАРЦУУЛСАН БАЙНА.*

Даланзадгад хот
2017 он

Агуулга

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт 3
Дарга, Тэргүүлэх аудитор Н.Отгонбаяр	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт 4-5
Аудитын менежер Д.Алдармөнх	Бүлэг 1 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 2.4 хувиар давуулан биелүүлжээ. 5-6
Ахлах аудитор Ш.Наран	Бүлэг 2 Орон нутгийн төсвийг бодитой, төсвийг үр ашигтай, аривлан хэмнэлттэй төлөвлөсөн боловч зарим зардлыг зарцуулахдаа төсвийн зарчмыг баримталж ажиллаагүй байна. 7-9
Аудитор Г.Цэрэнлхам	Бүлэг 3 Орон нутгийн төсвөөс улсын төсөвт шилжүүлэх орлого өмнөх оноос 67.5 хувиар өссөн байна. 10
Шинжээч С.Одончимэг Г.Шижирболд	Дүгнэлт Хавсралтууд Судалгаа 1 Судалгаа 2 Судалгаа 3 Судалгаа 4 Судалгаа 5 Судалгаа 6
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70533539, 70533552 дугаарын утсаар харилцана уу	
ХАЯГ: Өмнөговь аймаг Нутгийн удирдлагын ордон 305 тоот	



Товчилсон үгийн жагсаалт

СЯ	Сангийн яам
ЗГ	Засгийн газар
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
АТБӨЯХАТ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг

АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2016 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудитор Төрийн аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Орон нутгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

АУДИТЫН ЗОРИЛТ

Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг шалгаж, дүгнэлт гарган Төрийн аудитын газарт танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

-  Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл
-  Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл
-  Орон нутгийн төсвийн үр дүн
-  Орон нутгийн нэмэлт санхүүжилт

ХАМРАХ ХҮРЭЭ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуй нэгж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2016 оны санхүүгийн тайлан, судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалд тулгуурлан гүйцэтгэв.

АУДИТЫН АРГА ЗҮЙ

Аудитыг Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан Тэргүүлэх аудиторовн баталсан аудитын дэд төлөвлөгөөний дагуу нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

АУДИТ ХИЙСЭН БАГ, ХУГАЦАА

Аудитыг Тэргүүлэх аудитор Н.Отгонбаяр удирдаж, аудитын менежер Д.Алдармөнх чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ш.Наран, аудитор Г.Цэрэнлхам, шинжээч С.Одончимэг, Г.Шижирболд нар 2017 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн 04 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл ажлын 6 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Бүлэг 1

Орон нутгийн төсвийн орлогын
төлөвлөгөөг 2,4 хувиар давуулан
биелүүлжээ.

1.1 Орон нутгийн төсвийн орлогыг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөсөн байна.

Аймгийн 2016 оны төсвийн орлогыг Төсвийн тухай хуулийн 57¹, 58 дугаар зүйлийн 58.2², Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах" журам, аймгийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, холбогдох бусад хууль эрх зүйн актуудыг үндэслэн боловсруулжээ.

Орон нутгийн төсвийн нийт орлогын дээд хязгаарыг СЯ-наас 108,793.9 сая төгрөгөөр хянаж өгсөн боловч 4,318.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 112,401.5 сая төгрөгөөр баталсан байна.

2016 оны аймгийн нийт орлогыг АИТХурлын 2015 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 9-р хуралдааны 7 дугаар тогтоолоор 103,358.9 сая төгрөгөөр баталсан боловч 2016 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн 2-р хуралдааны 1 дүгээр тогтоолоор 7,238.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 110,597.3 сая төгрөгөөр тодотгон баталсан байна. Төсвийн тодотголоор:

- ✚ Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого, АТБӨЯХАТатварын орлого, Төсөвт байгууллагын өөрийн орлого, нэр зааж ангилаагүй орлого, татварын буцаан олголтыг нийт 2,827.6 сая төгрөгөөр, тусламжийн орлогыг 7,421.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн,
- ✚ Улсын тэмдэгтийн хураамжийн орлого, газрын төлбөрийн орлого, усны төлбөрийн орлого, хувьцааны ногдол ашгийн орлого, хүү торгуулийн орлого, хөрөнгө борлуулсны орлогуудыг нийт 3,010.5 сая төгрөгөөр бууруулсан.

Харин сумдууд аймаг, сумдын төсөвт төвлөрүүлэх орлогыг сумдын ИТХ-аар 1-3 удаа тодотгол хийж, 2,321.5 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

хүснэгт № 1

/сая.төгрөг/

2016 он

Үзүүлэлт	Өмнөх оны төлөвлөгөө	Сангийн яамны хянасан дүн	Анх батлагдсан дүн	Тодотгол- 1
ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ОРЛОГО	50,841.2	55,728.9	68,050.8	63,361.0
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	105,431.2	104,475.7	108,793.9	112,401.5
УРСГАЛ ОРЛОГО	74,081.9	55,578.9	67,795.4	63,193.2
Татварын орлого	61,883.9	53,972.2	59,459.9	57,052.1
Татварын бус орлого	12,198.0	1,606.8	8,335.4	6,141.1
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	87.7	150.0	255.4	167.7
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	31,261.6	49,022.7	40,743.2	49,040.5

¹ Орон нутгийн төсөв

² Аймаг өөрийн төсвөөр тухайн шатанд хамаарах дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ.

Төсвийн зарлагын төлөвлөгөөг ЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-ын дагуу аймаг, сум, багийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой цалин хөлсний зардлыг орон тооны жишигт үндэслэн ЗГ-аас баталсан төрийн албан хаагчийн цалин, нэмэгдлийн жишигээр, тогтмол зардлыг тухайн нутаг дэвсгэрт мөрдөгдөж байгаа үнэ тарифийн жишигээр, хувьсах урсгал зардлыг хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, алслалт зэрэг үзүүлэлтийг харгалзан мөн халамжийн зардал, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал зэргийг тооцон орон нутгийн төсвийн төлөвлөлтийг хийсэн байна.

ОНХНСангийн сумдад хуваарилах ОНХС-ын төлөвлөлтийг хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, алслалт, татварын идэвх санаачлага гэсэн үзүүлэлтүүдийг харгалзан тооцож, хуваарилан батлуулж, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг төсөвт байгууллагуудын төсвийг харьяа салбарын яамдад хүргүүлэн хянуулж аймгийн ИТХурлаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан байна.

1.2 Орон нутгийн төсвийн орлогыг 2,4 хувиар давуулан биелүүлсэн байна.

Өмнөговь аймаг 2016 оны орон нутгийн төсвийн орлого төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт орлого ба тусламжийн дүнг 112,401.5 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 115,153.4 сая төгрөгт хүрч, төлөвлөснөөс 2,751.9 сая төгрөгөөр, өмнөх оны гүйцэтгэлээс 20,144.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

хүснэгт № 2

ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	/сая.төгрөг/ 2016 он			
		Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	95,009.3	108,793.9	112,401.5	115,153.4	2,751.9
УРСГАЛ ОРЛОГО	65,158.7	67,795.4	63,193.2	65,885.2	1,629.9
Татварын орлого	60,146.6	59,459.9	57,052.1	65,807.7	3,185.6
Татварын бус орлого	5,012.1	8,335.4	6,141.1	5,570.0	-1,555.7
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	5.8	255.4	167.7	77.5	-90.2
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	29,844.8	40,743.2	49,040.5	49,268.2	227.7

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогын 52,3 хувийг татварын орлого, 3,9 хувийг татварын бус орлого, 43,8 хувийг тусламжийн орлого бүрдүүлсэн байна.

Орон нутгийн татварын орлого 2,8 хувиар буюу 3,185.6 сая төгрөгөөр, тусламжийн орлого 0,2 хувиар буюу 227.7 сая төгрөгөөр тус тус давуулан биелүүлж, татварын бус орлого 1,0 хувиар буюу 1,555.9 сая төгрөгөөр, хөрөнгийн орлого 90.2 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Бүлэг 2

Орон нутгийн төсвийг бодитой, төсвийг үр ашигтай, аривлан хэмнэлттэй төлөвлөсөн боловч зарим зардлыг зарцуулахдаа төсвийн зарчмыг баримталж ажиллаагүй байна.

2.1 Орон нутгийн төсвийг үр ашигтай, аривлан хэмнэлттэй төлөвлөсөн байна.

Өмнөговь аймгийн орон нутгийн төсвийн зарлагыг аймаг, сумдын ИТХ-ын хуралдаанаар өмнөх оноос 28,777.6 сая төгрөгөөр өсгөн, 2016 онд 1 удаагийн тодотголоор 4,650.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 118,183.6 сая төгрөгөөр баталжээ.

хүснэгт № 3

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны төлөвлөлт	2016 он		
		Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Зөрүү +/-
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	89,406.0	113,532.8	118,183.6	4,650.8
УРСГАЛ ЗАРДАЛ	40,147.9	65,837.3	63,417.3	-2420.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	33,724.6	38,688.4	39,757.5	1,069.1
ТАТААС	144.2	173.4	183.0	9.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,279.1	26,975.5	23,476.8	-3,498.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	49,258.1	47,695.5	54,766.3	7,070.8

Орон нутгийн нэгдсэн төсвийн нийт зарлагын дүнд урсгал зардал 53,7 хувийг, хөрөнгийн зардал 46,3 хувийг, өмнөх оны гүйцэтгэлээс урсгал зарлага 23,269.4 сая төгрөг, хөрөнгийн зардал 5,508.2 сая төгрөгөөр өссөн байна.

Орон нутгийн төсвийг тодотгохдоо:

- ✚ Сумдад олгох санхүүгийн дэмжлэг 4,081.2 сая төгрөгөөр,
- ✚ ТЕЗ-ийн шууд харьяалал бүхий төсөвт байгууллагууд 8,812.8 сая төгрөгөөр,
- ✚ Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга 377.7 сая төгрөгөөр,
- ✚ Сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 8,938.5 сая төгрөгөөр,
- ✚ Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын зардал 21,353.8 сая төгрөгөөр,
- ✚ Орон төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт 15,739.1 сая төгрөгөөр,
- ✚ Байгаль хамгаалах чиглэлээр хийгдэх хөрөнгө оруулалт 7,020.9 сая төгрөгөөр,
- ✚ Сумдад олгох тусгай зориулалтын шилжүүлэг 27,524.5 сая төгрөгөөр,
- ✚ ОНХНСанд төвлөрүүлэх хөрөнгө 11,279.0 сая төгрөгөөр
- ✚ Улсын төсөвт төвлөрүүлэх 5,469.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

2.2 Орон нутгийн төсвийг төлөвлөгөөний дагуу зарцуулсан байна.

Орон нутгийн төсвийн нийт зарлага 107,745.4 сая төгрөгт хүрч, төлөвлөснөөс 8,8 хувь буюу 10,438.2 сая төгрөгөөр хэмнэж ажилласан байна. Зарлагын гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулахад 26,237.1 сая төгрөгөөр буюу 32,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

хүснэгт № 4		/сая.төгрөг/			
Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2016 он			
		Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	81,508.3	113,532.8	118,183.6	107,745.4	(10,438.2)
УРСГАЛ ЗАРДАЛ	38,436.0	65,837.3	63,417.3	60,710.2	(2,707.1)
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,134.1	38,688.4	39,757.5	37,343.8	(2,413.7)
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,837.3	20,920.1	21,090.5	20,875.7	(214.8)
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,143.8	2,304.1	2,381.7	2,342.5	(39.2)
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,522.6	4,375.6	4,394.1	4,238.9	(155.2)
Хангамж, бараа материалын зардал	1,356.8	1,501.0	1,681.9	1,649.1	(32.8)
Нормативт зардал	2,075.5	2,257.4	2,263.3	2,256.4	(6.9)
Эд хогшил, урсгал засварын зардал	522.1	671.8	977.7	915.0	(62.7)
Томилолт, зочны зардал	175.3	184.3	201.6	175.9	(25.7)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	639.3	2,658.7	2,383.0	2,279.1	(103.9)
Бараа үйлчилгээний бусад зардал	1,861.4	3,815.4	4,383.7	2,611.2	(1,772.5)
ТАТААС	137.8	173.4	183.0	180.1	(2.9)
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	137.8	173.4	183.0	180.1	(2.9)
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,164.1	26,975.5	23,476.8	23,186.3	(290.5)
Засгийн газрын урсгал шилжүүлэг	24.8	20,534.6	16,789.9	16,789.4	(0.5)
Бусад урсгал шилжүүлэг	6,139.3	6,440.9	6,686.9	6,396.9	(290.0)
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	43,072.3	47,695.5	54,766.3	47,035.2	(7,731.1)
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	81,353.9	113,532.8	118,183.6	112,752.7	(5,430.9)
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	29,265.0	43,486.8	51,861.8	49,588.4	(2,273.4)
Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	-	2,820.5	2,907.8	1,053.3	(1,854.5)
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	24,590.1	27,219.5	27,439.0	27,020.1	(418.9)
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	4,674.9	13,446.8	21,515.0	21,515.0	-
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	49,463.6	69,942.4	64,871.5	61,920.4	(2,951.1)
Орон нутгийн төсвөөс	49,463.6	69,942.4	64,871.5	61,920.4	(2,951.1)
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,468.3	103.6	1,450.3	1,243.9	(206.4)
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	157.0	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	177	119	119	119	0.0
Төсвийн байгууллага	177	119	119	119	0.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	2528	2667	2667	2527	-140.0
Удирдах ажилтан	203	210	210	183	-27.0

Өмнөговь аймгийн 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэх ажилтан	1553	1662	1662	1546	-116.0
Үйлчлэх ажилтан	683	719	719	776	57.0
Гэрээт ажилтан	89	76	76	22	-54.0
СУРАЛЦАГЧДЫН ТОО (жилийн дунджаар)	12334	12032	12032	11563	-469.0
Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид	8961	8606	8606	8195	-411.0
СӨБ байгууллагад суралцагч	3373	3426	3426	3368	-58.0

Аймаг, сумын төсвийн 2016 оны зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал:
хүснэгт №5

Үзүүлэлт	Зарлага			
	Төл	Гүйц	Зөрүү	Хувь
Баяндалай	2072.2	1674.4	397.8	80.8
Баян-Овоо	2051.4	1573.5	477.9	76.7
Булган	1562.6	1266.6	296.0	81.1
Гурвантэс	5623.5	3773.5	1850.0	67.1
Даланзадгад	12167.2	11283.5	883.7	92.7
Мандал-Овоо	1708.7	1585.9	122.8	92.8
Манлай	1788.7	1504.2	284.5	84.1
Номгон	1814.5	1483.8	330.7	81.8
БҮГД ДҮН				

Үзүүлэлт	Зарлага			
	Төл	Гүйц	Зөрүү	Хувь
Ноён	1596.1	1221.2	374.9	76.5
Сэврэй	1690.8	1451.1	239.7	85.8
Хүрмэн	1546.1	1454.6	91.5	94.1
Ханхонгор	1682.8	1633.2	49.6	97.1
Ханбогд	2860.2	2518.2	342.0	88.0
Цогт-Овоо	5632.1	4089.0	1543.1	72.6
Цогтцэций	1583.4	1445.5	137.9	91.3
Аймаг	72803.4	69787.3	3016.1	95.9
	118183.7	107745.5		

Хөрөнгийн зардалд 15,727.3 сая төгрөг буюу 33,4 хувийг их засвар, 31,307.9 сая төгрөг буюу 66,6 хувийг хөрөнгийн бусад зардал тус тус эзэлж байна.

ТЕЗ-ийн төсвийн зарлагад эзлэх хувийг зардлын
бүлгээр зургаар харуулвал:



Зургаас харахад хөрөнгийн зардал 47035.2 сая төгрөг буюу 43.6 хувь, цалингийн зардал 20875.9 сая төгрөг буюу 19.4 хувь, бараа үйлчилгээний бусад зардал 16648.0 сая төгрөг буюу 15.5 хувь, урсгал шилжүүлэг 23186.4 сая төгрөг буюу 21.5 хувийг тус тус эзэлж байна.

Бүлэг 3

Орон нутгийн төсвөөс улсын төсөвт шилжүүлэх орлого өмнөх оноос 67.5 хувиар өссөн байна.

2016 онд орон нутгийн төсвөөс улсын төсөвт 16,748.6 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 16,748.6 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлж, өмнөх онтой харьцуулахад 6,746.5 сая төгрөгөөр буюу 67,5 хувиар өссөн байна.

Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн 82 байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 3,232.6 сая төгрөгийн санхүүжилтийг авч, 3,232.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

<i>Салбарын болон байгууллагын нэр</i>	<i>2016 он</i>		
	<i>Санхүүжилт</i>	<i>Зарцуулалт</i>	<i>Үлдэгдэл</i>
Орон нутгийн байгууллагууд	2,001.10	2,001.10	0
Аймгийн төвийн ТШЗ	795.0	795.0	0
Бусад ТШЗ байгууллагууд	436.5	436.5	0
ДҮН	3,232.6	3,232.6	-

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 2,4 хувиар давуулан биелүүлжээ.
2. Орон нутгийн төсвийг бодитой, төсвийг үр ашигтай, аривлан хэмнэлттэй төлөвлөсөн боловч зарим зардлыг зарцуулахдаа төсвийн зарчмыг баримталж ажиллаагүй байна.
3. Орон нутгийн төсвөөс улсын төсөвт шилжүүлэх орлого өмнөх оноос 67.5 хувиар өссөн байна.
4. Орон нутгийн төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй төлөвлөж, зарцуулсан байна.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Н.ОТГОНБАЯР